**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 26 өдөр Дугаар А/328 Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 70 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансt шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 15,356,000.00 (арван таван сая гурван зуун тавин зургаан мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэгийн балансаас балансt шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 70 дугаар сургууль (М.Түвшинжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн хүүхдийн 94 дүгээр цэцэрлэг (Б.Алтаннавч)-т даалгасугай

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

1425030852

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны ..09.. дугээр сарын ..16..-ны өдрийн ..А/48.. дугаар тушаалын хавсралт

Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 70 дугаар сургууль

| № | Эд хөрөнгийн нэр | Марк үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад авсан он | Нэгж үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл /2025.09.30/ | Нийт үлдэгдэл | Шилжүүлэн авах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Жигнүүр 12 листтэй | хятад | ш | 1 | 2025.04.21 | 898,000.00 | 898,000.00 | 29,933.34 | 868,066.66 | Баянгол дүүргийн 94 дүгээр цэцэрлэг |
| 2 | Махны машин | хятад | ш | 1 | 2025.04.21 | 1,480,000.00 | 1,480,000.00 | 49,333.34 | 1,430,666.66 | |
| 3 | Хөлдөөгч | хятад | ш | 1 | 2025.04.21 | 1,800,000.00 | 1,800,000.00 | 75,000.00 | 1,725,000.00 | |
| 4 | Аяга таваг угаагч машин | хятад | ш | 1 | 2025.04.21 | 10,200,000.00 | 10,200,000.00 | 340,000.00 | 9,860,000.00 | |
| 5 | Ус буцалгагч 80 л | хятад | ш | 1 | 2025.04.21 | 598,000.00 | 598,000.00 | 24,916.66 | 573,083.34 | |
| | **Машин, тоног төхөөрөмжийн дүн** | | ш | 1 | | | **14,976,000.00** | **519,183.34** | **14,456,816.66** | |
| 6 | Хоол унд зөөх тэргэнцэр | хятад | ш | 1 | 2025.04.21 | 380,000.00 | 380,000.00 | 332,500.04 | 47,499.96 | |
| | **Тавилга, эд хогшлийн дүн** | | | | | | **380,000.00** | **332,500.04** | **47,499.96** | |
| | **Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн** | | | | | | **15,356,000.00** | **851,683.38** | **14,504,316.62** | |